

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**

2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ТАНИЛЦУУЛГА

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын эрхлэх асуудлын хүрээний Ус, цаг уур, орчны шинжилгээний төвүүдийн 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэсэн тухай

Нэг. Зорилго

Агентлагийн даргын эрхлэх асуудлын хүрээний 25 байгууллагын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, зөвлөмж өгөх зорилготой ажиллав.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын “Журам батлах тухай” 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг удирдлага болгон харьяа 25 байгууллагын ирүүлсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд үнэлэлт дүгнэлт өгөв.

Гурав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын “Үнэлгээний баг байгуулах тухай” 2025 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/280 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж харьяа 25 байгууллагын ирүүлсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд үнэлэлт дүгнэлт гарган, хяналт шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэв.

Дөрөв. Тайлант хугацааны ажлын гүйцэтгэл

Харьяа 25 байгууллага нь 85-100 буюу бүрэн хангалттай үнэлгээтэй гэж дүгнэгдсэн байна. (1дүгээр хавсралт)

Тав. Дүгнэлт

Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа 25 байгууллага нь 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд дараах асуудлыг анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Төвийн дарга өөрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах болон тайлагнахдаа Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалыг баримтлаагүй;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний биелэлтийг оновчтой, товч тодорхой (шийдвэрийн дугаар, хугацаа, чанар) нотлогдохуйц бичээгүй, хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хүрэх үр дүн тодорхойгүй төлөвлөснөөс биелэлтийг зөрүүтэй тайлагнасан, үр дүнг бус үйл явц, зурган мэдээ мэдээлэл бичсэн, үр дүнг хэмжих нэгжээр илэрхийлж тоон болон чанарын хэмжигдэхүйц утгаар тайлагнаагүй, өгүүлбэрээр бичсэн, зарим арга хэмжээний биелэлтийг бичиж ирүүлээгүй орхигдуулсан;
- Зорилтот түвшин, шалгуур үзүүлэлт хэрэгжих боломжтой тоон болон чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц, үр дүнг харуулаагүй;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа ижил төрлийн ажил үйлчилгээг давхардуулж төлөвлөсөн;
- Хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагнахдаа үр дүнд суурьлаагүй;

- Тайланг хэт товч эсвэл хэт дэлгэрэнгүй тайлагнаж тухайн ажлын хүрэх үр дүнг илэрхийлээгүй;

Зөвлөмж

Дараах зөвлөмжийг анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж shilen.gov.mn сайт дээр тайлан, мэдээллээ хуульд заасан хугацаанд бүрэн оруулах, хариуцах албан хаагчийг томилон тус ажлыг жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж биелэлтийг тайлагнах;
- Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын 5.2 дахь заалт буюу Аймаг, нийслэл, сум, дүүргийн босоо удирдлагатай байгууллагын албан хаагчийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг харьяалах дээд шатны байгууллагын удирдлага үнэлэхдээ тухайн шатны Засаг даргын Тамгын газрын даргын саналыг тусгах заалтыг хэрэгжүүлэх;
- Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар журамд нийцүүлж биелэлтийг тайлагнах;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөхдөө хүрэх зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг хэрэгжих боломжтой тоон болон чанарын утгаар илэрхийлэх эсвэл хэмжигдэхүйц төлөвлөх;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг баримт бичгийн боловсруулалтыг хангаж, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар болон баримт бичгийн стандартыг мөрдөж утга найруулгыг зөв илэрхийлж үг үсгийн алдаагүй тайлагнах;
- Тухайн салбарын шинжилгээний ажлын “Зорилт”, “Арга хэмжээ”-нүүд хэт задалсан биш аймаг бүрт ижил загвартай байхад хариуцсан газар, хэлтсүүд зөвлөмж өгч ажиллах;
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ч бодит шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон эсвэл бүрэн хэрэгжсэн, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон ажлаа тодорхой шалтгааныг бичиж, хасах санал тусгаж хэвших;
- Тайланг тухайн ажлын хүрэх үр дүнд нийцүүлж, журамд заасан тэмдэгтэд багтааж, товч бөгөөд тодорхой тайлагнах байх;
- Сэтгэл ханамжийн судалгааг хийлгэж байх;
- “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж мэдээллийг үнэн зөв цаг хугацаанд нь бүрэн оруулахад анхаарч ажиллах

ТАНИЛЦСАН:

ДАРГА



Э.БАТТУЛГА

2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ДАРГА:

ХЯНАЛТ, ДОТООД

АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Х.ОЮУНБИЛЭГ

2026 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр

ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ГИШҮҮД:
НИСЛЭГ, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЦАГ УУРЫН УЛСЫН
СҮЛЖЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Г.Амгалан* Г.АМГАЛАН

2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр
УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ ГАЗРЫН
ОРОН НУТГИЙН УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ
ХАРИУЦСАН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР *Э.Дариймаа* Э.ДАРИЙМАА

2026 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр
ЦАГ АГААРТ ЗОРИУДААР НӨЛӨӨЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *М.Солонгоо* М.СОЛОНГОО

2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр
МЭДЭЭЛЛИЙН САН ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН *П.Тамир* П.ТАМИР

2026 оны ... дүгээр сарын ...-ны өдөр
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ДОТООД
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДОТООД ХЯНАЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *С.Наранчимэг* С.НАРАНЧИМЭГ

2026 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ УЛСЫН СҮЛЖЭЭ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *С.Энхмаа* С.ЭНХМАА

2026 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ЭРХ ЗҮЙ,
ГЭРЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Т.Болор-Эрдэнэ* Т.БОЛОР-ЭРДЭНЭ
2026 оны 1... дүгээр сарын 14-ны өдөр